SHANZAI
Rissho Kosei-kai Vol. 76
We Wish You a Very Happy New Year!! 1 2012

THE WORLD OF THE LOTUS SUTRA

# Цагаан Лянхуа Цэцгийн Судар

## Зөгнөлийн үг авсан таван зуун шавь, 8-р бүлэг (Part 1)

Шагжамүни нь олон шавь нараа бурхан болж чадна гэж зөгнөсөн учраас Пүрна өмнөх амьдралдаа ч Буддатай гүн уялдаа холбоотой байсан гэдгээ мэдэрчээ.Тэгээд сэтгэл нь ариусч,маш их баярлан хөөрсөн байна:"Буддагийн ач буяныг бидний үгээр хэлээд барашгүй.Бид сэтгэлийнхээ гүнд заавал Буддагийн гэгээрэлд хүрнэ гэсэн хүсэлтэй байгааг Шагжамүни та сайн ойлгож байгаа биз ээ."

Тэгтэл Шагжамүни нь бүх хүмүүст хандаж ингэж хэлэв:"Пүрна бол миний сургаалыг мөрдөн дагаж,өнгөрсөн ертөнцөд ч Буддагийн сургаалыг өрнүүлж ирсэн юм.Ялангуяа сургаалыг айлтгахдаа маш их чадварлаг хүн юм.Тэрээр ямагт ариун сэтгэлээр сургаалаа айлдаж,бодисадвагийн бурханлаг чанарыг агуулсан боловч хэзээ ч онгироо зан гаргадаггүй учраас хүмүүс түүнийг шёмоны гэгээрлийн хүрээнд л байгаа гэж боддог байсан.Пүрна ийнхүү хүмүүст тус болж,сургаж,тэднийг дээдсийн гэгээрэлд хүргэж өгч чадсан юм".

Тэгээд Шагжамүни нь Пүрнад Будда болох баталгаа өгчээ:"Пүрна гэгээрэлд хүрсний дараа Дарма Гэрэлтүүлэгч Будда болж,энх тайван үзэсгэлэнт орныг бий болгоно."

Үүнийг дуулсан мянга хоёр зуун архатууд ч зөгнөлийн үг авахыг хүссэн тул Шагжамүни нь Махакашьяпад хандаж ийнхүү хэлэв:

"Энд цугласан архатууд ч бүгд Гэгээн Гэрэл Цацруулсан Будда болно.Мөн энд байсан таван мянган хүмүүс ч мөн будда болно гэдгийг дамжуулан хэлээрэй" гэж будда болох баталгаа өгөв.

Зөгнөлт баталгааг авсан архатууд маш их баярлаж,өөрсдийнхөө дутагдалыг наминчлан ярив:"Бид төрөлхийн бурханлаг чанартай тул даяан хийснээр яваандаа Буддагийн оюун ухаанд хүрэх ёстой байхад бид зөвхөн тээнэгэлзэх сэтгэлээ л хаявал гэгээрэлд хүрчихэнэ гэж боддог байв".

Мөн тэд өөрсдийнхөө гэгээрсэн явдлаа жишээ яриагаар тайлбарлав:

(To be continued)



Ерөнхийлөгчийн сургаал

# Өөрийн сэдэвтэй байж

РКК-ийн Ерөнхийлөгч
**Нивано Ничико**

## “Хэрхэн яаж амьдрах вэ?” гэж өөрөөсөө асуу



Та бүхэнд Шинэ Оны мэнд хүргэе.”Жилийн төлөвлөгөө нь Шинэ Оны эхний өдөрт эхэлдэг”гэгчээр оны эхээр олонхи хүмүүс жилийнхээ төлөвлөгөө болон зорилго,сэдвээ бодож шийддэг байна.Буддын сургаалын замыг даган явдаг бидний хувьд зорилго сэдвээ шийдэхэд юуны өмнө бодисадвагийн үйл нь бүх зүйлийн үндэс болох ёстой билээ.

Бодисадвагийн үйл гэхлээр их л хэцүү зүйл юм шиг санагдах боловч үнэндээ тийм ч хүндээр бодох зүйл биш юм.Үүсгэн Байгуулагч маань:”Ажил хийнэ гэдэг бол бусдыг жаргаана гэсэн үг юм”гэж хэлдэг байсны дагуу бид өдөр тутмынхаа амьдрал дээрээ бусдыг нигүүлсэхүйн бодож,бусдыг баярлуулахын тулд өөрөө юу хийж чадах вэ гэдгээ л сайн бодож байвал болно.Ийнхүү ойр орчин тойрноосоо эхэлж бодисадвагийн үйлд зорьсноор өөртөө таарсан зорилго,сэдвээ олж болох юм.

Мөн энэ бол хэн нэгнээр заалгаж,заавардуулах зүйл биш юм.Хүн өөрөө өөртөө тавих ёстой “Би хэрхэн яаж амьдрах вэ?”гэсэн асуудалдаа хариулт олж,өөрийн гэсэн зорилго,сэдвээ сонгож шийдэх хэрэгтэй.

## Амьсгалж байгаатай адил

Цаганд автагдаж,өөрийн эрхгүй амьдралаа үнэ цэнгүй дэмий өнгөрөөдөг хүмүүс бидэнд зорилго,сэдэвээ олно гэдэг бол маш том ач холбогдолтой зүйл билээ.

Яриагаа өргөжүүлбэл,хүмүүс бидний амьдралд хязгааргүй их боломж байдаг юм.Үүний дотор “Би ингэж амьдармаар байна”гэсэн тодорхой зорилготой хүн ба зорилгогүй хүний аливаа юманд хандах байдал нь тэс өөр билээ.Хүмүүс олуулаа цугларсан үед ярих сэдэвтэй байвал яриа хөөрөө ч амжилттай явагдах билээ.

Хятад уруу даяанчлалаар явж байсан Доген зэн лам нь нэгэн сүмд зуны халуунд малгай ч өмсөлгүй мөөг хатааж ажиллаж байсан хөгшин ламыг хараад гайхан ингэж асуусан байна:”Та яагаад өөр залуу шавь нараа зардаггүй юм?”.Үүнд хөгшин лам :”Хүн зарвал би даяан хийсэн болохгүй”гэв.”Та тэгвэл ядаж жаахан сэрүүхэн болохоор ажиллавал яасан юм?”гэхэд хөгшин лам нь”Цаг хугацаа бол одоо л байна”гэж хариулсан гэдэг.Энэхүү явдал нь цаг хугацаа гэдэг нь одоо л байдаг бөгөөд хүн өөрийн зорилготой байхад бүх бие сэтгэлээрээ түүнийхээ төлөө зүтгэн чармайж чаддаг гэдгийг үзүүлсэн байна.

Мөн бусад хүний нүдэнд шалихгүй жижиг ажил гэж харагддаг зүйл ч “Би бол ингэж амьдармаар байна”гэсэн өөрийн хүсэл тэмүүлэлтэй нийцсэн л байвал бодисадвагийн үйл болдог юм.

Тийм ч утгаар “За,одоо зорилго,сэдвээ шийдлээ”гэж хүч гарган бодож ядах биш харин амьсгалж байгаатай адил ямар ч үед аяндаа хийж чадах зүйлийг л өөрийн сэдэв болговол таарна.

Талархах сэтгэлээ мартахгүй байх,уурлахгүй байх,хүн муулахгүй,бусдыг жаргаах......Агшин бүрийн ийнхүү чармайлт нь өөрийн дүнгээ үзүүлж,хүн амьдралаа үнэнчээр өнгөрүүлж,өөрийгөө ариусган боловсруулдаг байна.Энэ бол бүх хүмүүст хамаарагдах нийтлэг зорилго ба сэдэв юм.

Бид яг одоо энэ агшинд,энэ газар дээрээ л амьдарч байгаа билээ.Нүдний өмнө байгаа зүйлдээ баярлан талархаж амьдарвал хэн ч сэтгэл дүүрэн,утга учиртай амьдралтай болно.

“Косэй”2012 оны 1 сарын дугаараас



# Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК-ын дараах үеийн ерөнхийлөгч
Нивано Коошо багш

## Буцалтгүй хайр

Хүүхдээ хайрлах эцэг эхийн хайрыг “буцалтгүй хайр”,”үнэлэгдэхгүй хайр” гэж хэлдэг билээ.Нээрэй ч,эх эцэг нь өөрийгөө хойшид тавьж,нялх үрээ хөхүүлэн,хуурайлж,шөнө хэдэн цагт сэрсэн ч тэврэн унтуулдаг билээ.Хүүхэд халуурвал өөрөө хичнээн бие ядруу байсан ч нойроо хасаж хүүхдээ асрана.

Гэсэн ч энэ нь “буцалтгүй хайр” мөн үү гэвэл арай өөр юм шиг.Өдөр бүр хүүхдүүдийнхээ өсөж буй байдлыг харж,тэдний инээмсэглэл,хөөрхөн зан үйл,”ээжтэйгээ л байна”гэсэн ээждээ эрхлэх байдлыг харж баярлан хүүхэд өсгөх хэцүүг даван туулж чаддаг юм шиг санагдах юм.Өөрөөр хэлбэл,бид хүүхдүүдээсээ өдөр бүр бэлэг хүртдэг юм.

Хүүхэд томроод ирэхлээр нь эцэг эх нь хүүхэддээ “ээж аавынхаа үгэнд ордог хүүхэд л сайн”,”үгэнд ордоггүй хүүхэд бол муу”гэх мэтчилэнгээр “болзолтой хайр”-аар хүүхэддээ хандах явдал байдаг.Өөрөө арай гэж нэг хүүхдийнхээ ачаар эх хүн шиг харагдаж ирсэн байхад хүүхдээ өөрөө л өсгөөд өгсөн юм шиг санадаг.Үүнтэй харьцуулбал,хүүхэд бол аав,ээжийгээ үнэхээр “буцалтгүй хайр”-аар хайрладаг юм.

Том охин маань нялх байхдаа намайг хараад л “ээж ээ,ээж ээ”гэж уйлж ирдэг байсныг эмээ нь хараад “ийм залуу ногоон ээжээс над дээр ирсэн нь хамаагүй дээр байхад ээж дээрээ л очих юм даа”гэдэг байв.

Үүнийг сонсоод ядарсан үедээ хүүхэддээ “бушуу унт,бушуул”гэж уцаарлан уурладаг байсан өөртөө гэмшиж,охины минь тэр бяцхан биенд нь ямар их агуу хайр байгааг мэдэрсэн юм.

Энэ явдал нь оны эхэнд болсон юм.Харанхуй үүрийн цагаар гүнгэрваанынхаа идээг солихоор доошоо буух гээд хүүхдийн өрөөний хажуугаар өнгөртөл өрөөнөөс нь улаан гэрэл тусаж байх юм.Чийгшүүлэгч аппаратын ус нь дууссан болов уу гэж бодтол нэг хүнд юманд тээглээд номын шүүгээний буланд нүүрээ цохичихсон юм.Идээгээ яаж ийж байгаад сольчихоод бэртсэн газар хэт их

**Нивано Коошо**



Нивано Ничико ерөнхийлөгчийн том охин болж Токиод мэндэлсэн.
Хуулч мэргэжлээр их сургуулиа дүүргэсний дараагаар РКК-ын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакурин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.
Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа Косей Кайгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашинтнуудын хамтын ажиллагаан дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн дараа үеийн ерөнхийлөгчөөр сонгогдох дияаны үйлээ үргэлжлүүлсээр байгаа. Мүнэхиротой гэрлэсэн бөгөөд нэг хүү, гурван охины ээж болсон.

өвдсөнөөс болж бие муудаад буйдан дээр хэвтэж байтал хүүхдүүд сэрээд буугаад ирэв.Хүүхдүүд намайг хараад “Та яасан бэ?”гэж гайхан асуухад нь учрыг тайлбарлан ярьсан юм.Тэгтэл хүүхдүүд маань хоорондоо тохиролцсон юм шиг л “өө,хөөрхий зайлуул”гэж амандаа бувтнан намайг тэвэрч илэн өрөвдөвХэн нь ч “замаа сайн харж явахад яадаг юм”гэж намайг зэмлээгүй.

Хүүхэд бэртэж гэмтэхээр “хүн хэлээд байхад сайн анхааралтай байхад яадаг юм”гэж дандаа хэлдэг байсан өөрийнхөө үгийг санаж,хүүхдүүдийн маань гарнаас илчлэгдэх хайранд нь уярч,нулимс гарсан билээ.Нулимсыг маань хараад хүүхдүүд “яасан,өвдөж байна уу?”гэж санаа зовсон байдалтай асуусцгаав.”Үгүй,үгүй,ээж нь өвдсөндөө биш та нартаа сайхан халамжлуулаад хүүхэд болсон юм шиг санагдаад их баярласандаа нулимс гарчихлаа”гэхэд тэд шууд том хүн шиг царайлаад “Зүгээр,зүгээр сайн хүүхэд”гээд толгойгыг минь илж өгсөн юм.

Дараагаар нь хамартаа гурван ширхэг зүү хатгуулан оюулсан ч өвдөж зовсон гэхээс илүү хүүхдүүдийнхээ “буцалтгүй хайр”-ын хүчинд дийлэгдэж,хамран дээрх боолтоосоо ичиж зовох байтугай бүр бахархмаар сэтгэлээр тэр өдөрт гадаадын зочидтой уулзаж,маргааш нь ном уншлагын цуглаандаа ч оролцсон юм.

“Якүшин” сэтгүүл 11 сарын дугаараас



# Эхлээд нэг хүнээс эхэлдэг

Өөрийн амь нас аюулд тулгарсан үед хүн хамаг хүчээрээ зүтгэж,чин сэтгэлээсээ бурханд мөргөдөг.Энэ бол хэн ч адилхан хийдэг жирийн үзэгдэл юм.Гэвч бусад хүмүүсийн аз жаргалын төлөө өөрийгөө золиосолж,Буддагийн хөл гар болж амьдралаа өнгөрүүлэх нь хэр баргийн хүнд чадах зүйл биш билээ.Буянтай үйл хийж байхад орчин тойрны хүмүүс ойлгохыг ч хүсэлгүй элдвээр шүүмжлэн муулах явдал ч байдаг.

Дэлхийн шашны сүсэгтнүүдийн холбооны гишүүд бид ч Вьетнамын цагаачдыг аврах үйл ажиллагаагаа явуулж байхад олны шүүмжлэлд нэрвэгдсэн билээ.Гэсэн ч зориг гаргаж,өөрийгөө умартан хамаг сэтгэлээрээ буяныхаа үйлээ хийж гүйцээсний дараа үүнийг заавал ойлгож үнэлдэг хүн ч гарч ирдэг юм.Шашны сүсэгтнүүд бидний хийсэн тэрхүү буяны үйл ажиллагааны ачаар дэлхийн олон орнууд энэ асуудалд анхаарлаа төвлөрүүлж,Японы улс төрийн засаг ч Вьетнамын цагаачдыг аврах үйл ажиллагаанд наштай хандаж эхэлсэн билээ.

Манай дэлхийн газар дээр анх зам гэдэг юм анхнаасаа байгаагүй байсан юм.Эхлээд нэг хүн алхаж,араас нь бусад нь алхаж,олуулаа нэг зам дагасаар зам бий болсон юм.Манай байгууллага үндсээ тавьснаас хойш бид хамтдаа буддын сургаалын замаар 40 жил явлаа.Үүнээс хойш ч замаасаа мултарахгүйгээр хамтдаа алхан явцгаая.

Үүсгэн Байгуулагчийн Үг 5（Kosei Publishing Co.）, 26-27х

## Рисшо Косей Кайгийн тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Нивано Никкё болон Наганума Мёко нарын санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Манай байгууллага нь "Лянхуа цэцгийн гурван судар"-ыг номлолынхоо эх үүсвэр болгож, тэр бүлээрээ шүтэх шашины нэгэн шинэ хэлбэр бөгөөд сургаалийг амьдрал ахуй, нийгэмд хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайваныг зорьдог юм.




SHAN-ZAI　Volume 76（January 2012）

[Эрхлэн гаргач] Рисшо Косей Кай Сургаал дэлгэрүүлэх олон улсын төв.
**Хаяг:** Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo 166-8537 Japan **TEL:** 03-5341-1124 FAX: 03-5341-1224 **E-mail :** shanzai@kosei-kai.or.jp

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Солонгос хэл дээр тогтмол хэвлэгдэн гардаг бөгөөд зарим дугаар нь бусад орны хэл дээр ч хэвлэгдэн гардаг. ※Санал, сэтгэгдэл байвал бидэнтэй холбоо барина уу. ※Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын салбартай холбоо барина уу.

Rissho Kosei-kai

# Overseas Dharma Centers 2012

## Rissho Kosei-kai International
5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
*Tel:* 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

### Rissho Kosei-kai International of North America (RKINA)
4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
*Tel:* 1-949-336-4430 *Fax:* 1-949-336-4432
*e-mail:* info@rkina.org http://www.buddhistcenter-rkina.org

### Branch under RKINA
**Rissho Kosei-kai of Tampa Bay**
2470 Nursery Rd.Clearwater, FL 33764, USA
*Tel*: (727) 560-2927
*e-mail*: rktampabay@yahoo.com
http://www.rkina.org/tampabay

### Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
*Tel*: 66-2-716-8141 *Fax*: 66-2-716-8218
*e-mail*: thairissho@csloxinfo.com

### Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii
2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
*Tel:* 1-808-455-3212 *Fax:* 1-808-455-4633
*e-mail:* info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

**Rissho Kosei-kai Maui Dharma Center**
1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
*Tel:* 1-808-242-6175 *Fax:* 1-808-244-4265

**Rissho Kosei-kai Kona Dharma Center**
73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96750, U.S.A.
*Tel:* 1-808-325-0015 *Fax:* 1-808-333-5537

### Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles
2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
*Tel:* 1-323-269-4741 *Fax:* 1-323-269-4567
*e-mail:* rk-la@sbcglobal.net http://www.rk-la.com

**Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio**
6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
*Tel:* 1-210-561-7991 *Fax:* 1-210-696-7745
*e-mail:* dharmasanantonio@gmail.com

**Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**

**Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**

### Rissho Kosei-kai of San Francisco
1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
*Tel:* 1-650-359-6951 *Fax:* 1-650-359-5569
*e-mail:* rkksf@sbcglobal.net

**Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center**
28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
*Tel:* 1-253-945-0024 *Fax:* 1-253-945-0261
*e-mail:* rkseattle@juno.com

**Rissho Kosei-kai of Sacramento**

**Rissho Kosei-kai of San Jose**

**Rissho Kosei-kai of Vancouver**

**Lotus Buddhist Circle**
851 N. San mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.

### Rissho Kosei-kai of New York
320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
*Tel:* 1-212-867-5677 *Fax:* 1-212-697-6499
*e-mail:* koseiny@aol.com

**Rissho Kosei-kai of Chicago**
1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
*Tel & Fax:* 1-847-394-0809
*e-mail:* murakami4838@aol.com

### Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma
2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
*Tel & Fax:* 1-405-943-5030
*e-mail:* ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

**Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls**
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
*Tel:* 1-541-810-8127

**Rissho Kosei-kai, Dharma Center of Denver**
4340 E Kentucky Ave #345 Glendale, CO 80234, U.S.A.
*Tel:* 1-303-319-2765 *Fax:* 1-720-876-4534

**Rissho Kosei-kai Dharma Center of Dayton**
446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A

### Risho Kossei-kai do Brasil
Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
*Tel:* 55-11-5549-4446 *Fax:* 55-11-5549-4304
*e-mail:* risho@terra.com.br http://www.rkk.org.br

**Risho Kossei-kai de Mogi das Cruzes**
Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
*Tel:* 55-11-4724-8862

### Rissho Kosei-kai of Taipei
4F, No. 10 Hengyang Road, Jhongjheng District, Taipei City 100
*Tel:* 886-2-2381-1632 *Fax:* 886-2-2331-3433

**Rissho Kosei-kai of Taichung**
No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
*Tel:* 886-4-2215-4832/886-4-2215-4937 *Fax:* 886-4-2215-0647

**Rissho Kosei-kai of Jilung**

### Rissho Kosei-kai of Tainan
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
*Tel:* 886-6-289-1478 *Fax:* 886-6-289-1488

**Rissho Kosei-kai of Pingtung**
No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
*Tel:* 886-8-732-1241 *Fax:* 886-8-733-8037

### Korean Rissho Kosei-kai
423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
*Tel:* 82-2-796-5571 *Fax:* 82-2-796-1696
*e-mail:* krkk1125@hotmail.com

**Korean Rissho Kosei-kai of Pusan**
1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
*Tel:* 82-51-643-5571 *Fax:* 82-51-643-5572

**Korean Rissho Kosei-kai of Masan**

### Branches under the Headquarters
**Rissho Kosei-kai of Hong Kong**
Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic of China
*Tel:* 852-2-369-1836 *Fax:* 852-2-368-3730

**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**
39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
*Tel & Fax:* 976-11-318667
*e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Sukhbaatar**
18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

**Rissho Kosei-kai of Sakhalin**
1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk
693000, Russian Federation
*Tel & Fax:* 7-4242-43-78-56

**Rissho Kosei-kai (Geneva)**
1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
*Tel:* 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053
*e-mail:* rkkgva@wcc-coe.org

**Rissho Kosei-kai of the UK**

**Rissho Kosei-kai of Venezia**
Castello-2229 30122-Venezia Ve Italy
*Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)*

**Rissho Kosei-kai of Paris**
86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
*Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)*

**Rissho Kosei-kai of Sydney**

## International Buddhist Congregation (IBC)
5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
*Tel:* 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
*e-mail:* ibcrk@kosei-kai.or.jp http://www.ibc-rk.org/

# Rissho Kosei-kai of South Asia Division
85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
*Tel & Fax:* 880-31-2850238

## Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
*e-mail:* info.thairissho@gmail.com

## Rissho Kosei-kai of Bangladesh
85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
*Tel & Fax:* 880-31-2850238

**Rissho Kosei-kai of Dhaka**
House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
*Tel:* 880-2-8316887

**Rissho Kosei-kai of Mayani**
Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

**Rissho Kosei-kai of Patiya**
Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Domdama**
Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Cox's Bazar**
Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

**Rissho Kosei-kai of Satbaria**
Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Laksham**
Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

**Rissho Kosei-kai of Raozan**
West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Chendirpuni**
Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

## Rissho Kosei-kai of Sri Lanka
382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
*Tel:* 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**
No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

**Rissho Kosei-kai of Habarana**
151, Damulla Road, Habarana, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Galle**
No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Kandy-wattegama**
12 Station Road, Kapugastota, Sri Lanka

## Branches under the South Asia Division

**Delhi Dharma Center**
B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
*Tel:* 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
*e-mail:* sakusena@hotmail.com

**Rissho Kosei-kai of West Delhi**
A-139 Ganesh Nagar, Tilak Nagar
New Delhi-110018, India

**Rissho Kosei-kai of Kolkata**
E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

**Rissho Kosei-kai of Kathmandu**
Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
*Tel:* 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
*e-mail:* nrkk@wlink.com.np

**Rissho Kosei-kai of Lumbini**
Shantiban, Lumbini, Nepal

**Rissho Kosei-kai of Singapore**

## Other Groups

**Rissho Kosei-kai Friends in Shanghai**
1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,
Shanghai 200081 China